



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/176

Улаанбаатар хот

Жагсаалт, дүрэмт хувцасны иж бүрдэл,
загвар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадад шаардлагатай дэд бүтэц, тоног төхөөрөмжийн жагсаалтыг нэгдүгээр, албан хаагч, байгаль хамгаалагчдын албаны болон хээрийн хувцасны иж бүрдлийг хоёрдугаар, загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан жагсаалтын дагуу хамгаалалтын захиргаадад бүртгэлтэй эд хөрөнгөд тооллого зохион байгуулах, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, шаардлагатай дэд бүтэц, тоног төхөөрөмжөөр хангах, хэрэгжилт, ашиглалт, эзэмшилд хяналт тавьж ажиллахыг Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газар (Д.Батмөнх), Санхүү хөрөнгө, оруулалт үйлдвэрлэлийн хэлтэс (Б.Чойжил)-т тус тус үүрэг болгосугай.

3. "Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадад шаардлагатай дэд бүтэц, тоног төхөөрөмжийн жагсаалт"-д заасан дэд бүтэц, тоног төхөөрөмжөөр хангах, урсгал болон засвар үйлчилгээний зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган төлөвлөж, хэрэгжүүлж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс (Б.Чойжил), Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/176 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Б.БАТ-ЭРДЭНЭ

152211210



Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадад шаардлагатай дэд бүтэц, тоног төхөөрөмжийн жагсаалт

ДД	Багаж хэрэгслийн нэр төрөл	Ой хөвчийн бүс дэх ТХГН	Тал хээрийн бүс дэх ТХГН	Говь цөлийн бүс дэх ТХГН	Ус, намгархаг газар бүхий ТХГН	Тайлбар
Нэг. Барилга байгууламж						
1	Хамгаалалтын захиргааны албан оффис	1 ш	1 ш	1 ш	1 ш	Оффисын ажилтнуудын тоонд тохируулан МУ-ын барилгын тухай хууль, журам, стандартын дагуу зураг төслийг боловсруулж, барина.
2	Сургалт, мэдээллийн төв	Хамгаалалт, хяналт сурталчилгааны хэсгийн тоогоор				МУ-ын барилгын тухай хууль, журам, стандартын дагуу зураг төслийг боловсруулж, барина.
3	Байгаль хамгаалагчийн байр	Байгаль хамгаалагчийн тоогоор				Байгаль хамгаалагч суурин ажиллаж, амьдрах зориулалттай
4	Байгаль хамгаалагчийн пост	Онцгой анхаарах шаардлагатай газруудын тоогоор				Байгаль хамгаалагч хяналт шалгалт, мониторингийн үед түр ашиглах зориулалттай
5	Зөөврийн сууц	1-3 ш	1-2 ш	1-3 ш	1-2 ш	Улирлын чанартай онцгой хяналт шалгалт, мониторингийн үед түр ашиглах зориулалттай, жийп машинаар чирч зөөвөрлөх боломжтой.
6	Монгол гэр	1-5 ш	1-5 ш	1-5 ш	1-5 ш	5 ханатай, давхаргатай, бүрэн тавилгатай стандарт монгол гэр
7	Отоглох хоноглох цэг	Аялал жуулчлалын ач холбогдол бүхий газруудад				Стандарт зураг төслийн дагуу баригдсан байх
8	Зэрлэг амьтан ажиглах цэг	Аялагч, жуулчид, судлаачид зэрлэг амьтан, шувуу ажиглалт хийх боломжтой газруудад				Стандарт зураг төслийн дагуу баригдсан байх
Дээрх барилга байгууламжууд тавилга, компьютер, бусад тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон байна.						
Хоёр. Тээврийн хэрэгсэл						

1	Жийп автомашин	1-5 ш	1-4 ш	1-4 ш	1-3 ш	Хариуцан хамгаалдаг талбайн хэмжээ болон ажилтнуудын тооноос хамаарах
2	Ачааны автомашин	1-2 ш	1 ш	1 ш	1 ш	Элс, цас, бартаат зам туулах чадвар сайтай байх.
3	Мотоцикл	Хээрийн нөхцөлд ажиллах үүрэгтэй ажилтнууд болон байгаль хамгаалагчийн тоогоор				Туулах чадвар сайтай
4	Цасны мотоцикл	2-4 ш	-	-	2-4 ш	Туулах чадвар сайтай
5	4 дугуйт мотоцикл	2-4 ш	2 ш	2 ш	2 ш	Туулах чадвар сайтай
6	Моторт завь	2-4 ш	1-2 ш	-	2-4 ш	Гол мөрний тоо, нуурын талбайн хэмжээнээс хамаарах,
7	Хийлдэг завь	2-4 ш	1-2 ш	-	2-4 ш	Гол мөрний тоо, нуурын талбайн хэмжээнээс хамаарах,
8	Дугуйт трактор	1-3 ш	1-3 ш	1-2 ш	1-2 ш	Модны нүх ухах, өвс хадах, боох, газар хагалах, тээвэр хийх зориулалтын нэмэлт тоноглолтой байх.
9	Бохир ус зөөвөрлөх машин	1-2 ш	1 ш	1 ш	1-2 ш	Аялал жуулчлалын бааз, отоглох хоноглох цэг, бусад дэд бүтцийн нөхцөлтэй уялдуулан тоог тогтоох
10	Хог тээврийн машин	1-2 ш	1 ш	1 ш	1-2 ш	Хогийн тэвшийг өөрөө ачих буулгах хүчин чадалтай.
11	Морь	Хээрийн нөхцөлд ажиллах үүрэгтэй ажилтнууд болон байгаль хамгаалагчийн тоогоор				Судалгаа болон хяналт шалгалтын ажлын зориулалтаар ашиглах
Гурав. Хээрийн ажлын багаж хэрэгсэл						
1	Дуран	Хээрийн нөхцөлд ажиллах үүрэгтэй ажилтнууд болон байгаль хамгаалагчийн тоогоор				
2	Шөнийн харааны дуран	Хамгаалалт, хяналт сурталчилгааны хэсэг тус бүрд 2 ш				
3	Энгэрийн камер	Хээрийн нөхцөлд ажиллах үүрэгтэй ажилтнууд болон байгаль хамгаалагчийн тоогоор				Цагдаагийн хэрэгцээнд ашиглагдаж буй камертай дүйцэхүйц үзүүлэлттэй байх;
4	Гар чийдэн					
5	Гар утас					Смарт, Биосан гэх мэт программ ажиллах боломжтой,
6	Зай цэнэглэгч					10.000А-аас багагүй хүчин чадалтай


7	Радио холбооны суурин ба машины станц	5-8 ком	5-8 ком	5-8 ком	5-8 ком	25 ваттаас доошгүй гаралтын чадалтай, төвийн болон машины цахилгаан эх үүсвэрээр тэжээгддэг байх;
8	Радио холбооны гар станц	5-10 ком	5-10 ком	5-10 ком	5-10 ком	15 ваттаас доошгүй гаралтын чадалтай, батарей нь хүлээх горимд 250 цаг барих чадалтай байх;
9	Унтлагын хөнжил	Хээрийн нөхцөлд ажиллах үүрэгтэй ажилтнууд болон байгаль хамгаалагчийн тоогоор				
10	Аяны гудас					
11	Аяны үүргэвч цүнх					
12	Аяны майхан (2 хүний)	4-10 ш	4-10 ш	4-10 ш	4-10 ш	
13	Аяны майхан (4 хүний)	2 ш	2 ш	2 ш	2 ш	
14	Газын плитк	3 ш	3 ш	3 ш	3 ш	Стандартын хийн баллон угсардаг байх
15	Эвхдэг зуух	1 ком	-	-	1 ком	
16	Хээрийн нөхцөлд хоол чанах сав, аяга хэрэгсэл	3 иж бүрдэл	3 иж бүрдэл	3 иж бүрдэл	3 иж бүрдэл	Тогоо: 5-6л багтаамжтай, 4-6 ширхэг аяга, халбага бүхий, цүнх савтай байх.
17	Усны сав	3 ш	3 ш	3 ш	3 ш	20 литрээс доошгүй багтаамжтай байх
18	Анхны тусламжийн эм, хэрэгслийн сан	3 иж бүрдэл	3 иж бүрдэл	3 иж бүрдэл	3 иж бүрдэл	Зориулалт: Хөнгөн гэмтэл авсан хүнд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх иж бүрдэл.
Дөрөв. Судалгаа, мониторингийн ажлын багаж хэрэгсэл						
1	Дрон (Нисдэг Камер)	1-3 ш	1-3 ш	1-3 ш	1-3 ш	
2	Хөдөлгөөн мэдрэгч судалгааны камер /Автомат камер/	10-20 ком	10-20 ком	10-20 ком	10-20 ком	Камерын батарей цэнэглэгч болон батарей хангалттай хэмжээгээр байх
3	Телескоп дуран	2 ш	2 ш	2 ш	2 ш	
4	Мэргэжлийн түвшний зургийн аппарат	1 ком	1 ком	1 ком	1 ком	Нэмэлт дуран, хөл, цүнх болон бусад дагалдах хэрэгслийн хамт
5	GPS байршил тодорхойлогч	5-10 ш	5-10 ш	5-10 ш	5-10 ш	
6	Лазер зай хэмжигч багаж	5 ш	5 ш	5 ш	5 ш	

7	Зөөврийн компьютер	Судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн, хэсгийн ахлагчдын тоогоор				
Тав. Түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах багаж, тоног төхөөрөмж						
1	Түймэртэй тэмцэх автомашин	1 ком	1 ком	-	1 ком	ОБЕГ-аас тогтоосон чанар үзүүлэлтийг баримтлах ба түймэр унтраах тоноглолтой ОБЕГ-аас тогтоосон чанар үзүүлэлтийг баримтлах
2	Гал үлээгч аппарат	5-10 ком	5-10 ком	-	3-5 ком	
3	Цурамдагч аппарат	3-5 ком	3-5 ком	-	2-4 ком	
4	Үүргэвчийн ус шүршигч	10-20 ш	10-20 ш	-	5-10 ш	
5	Галд тэсвэртэй хувцас	5-10 ком	5-10 ком	-	3-5 ком	
6	Хүрз	10-20 ш	10-20 ш	-	10-20 ш	
7	Цахилгаан хөрөө	5 ш	5 ш	-	5 ш	
8	Сүх	5 ш	5 ш	-	5 ш	
Зургаа. Албан хаагчдын хувийн хамгаалах хэрэгсэл						
1	Цахилгаан бороохой	Хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн, байгаль хамгаалагчдын тоогоор				“Иргэний болон харуул хамгаалалтын ангилалд хамаарах галт зэвсэг, сумны нэр, төрлийн жагсаалт”-д багтсан бөгөөд цагдаагийн байгууллагаас баталсан техникийн үзүүлэлттэй дүйцэх үзүүлэлт, чанартай байх
2	Хийн буу эсвэл нулимс асгаруулагч					
3	Гав					
4	Цахилгаан бороохой					
5	Усны гутал	Хээрийн нөхцөлд ажиллах үүрэгтэй ажилтнууд болон байгаль хамгаалагчийн тоогоор				
6	Дах					
7	Дэгтий					
8	Нүдний шил					
9	Бээлий					
					Салхинаас хамгаалах	
					Нэхий болон савхин	

Жич: Тухайн тээврийн хэрэгсэл, барилга байгууламж, бусад тоног төхөөрөмжийг худалдан авахдаа орчин үеийн дэвшилтэт техник технологийн шаардлага хангахуйц техникийн үзүүлэлтийг гаргаж, мөрдлөг болгон ажиллана.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
 2022 оны 10 дүгээр сарын 26 өдрийн
 Д/М/Б дугаар тушаалын 2 дугаар хавсралт



Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны албан хаагчдын албаны болон хээрийн хувцасны иж бүрдэл

№	Хувцас хэрэглэлийн нэр	Материал хэрэглэлийн өнгө	Материал, бүтээцийн тодорхойлолт
1	Өвлийн хувцасны иж бүрдэл	Малгай	Хөх Материал: Малгайн чих, цох, ар шилний өнгө нь ижил, үс өндөр намгүй жигд 1,5 см өндөртэй хиймэл үс байна. Хиймэл үсний ширхэг дээшээ налсан байна. Малгайн тэмдэг: Зууван цэнхэр өнгийн суурин дээр Алтан соёмбыг товойлгосон тариан түрүүний дүрслэл бүхий хүрээтэй байна Дотор: Малгайн орой болон хүрээ хэсгийг битүү ширж оёно Хар өнгийн дотрын материалтай, Малгайн чих, цох, ар шилийг зузаан ширмэл зулхайг давхарлан доторлосон байна. Өнгө нь хар хөх, хөх саарал байна. Бүч: 15 см урт, 0.8 см өргөнтэй, өнгө дагуу даавуун материалаар хийнэ. 2 чих нь буудаг.
		Гадуур хүрэм	Хар ногоон Орц: полиестр 65%, хөвөн 35%, Жин: 1м2-д 240гр, Зах: малгайтай ижил материал, өнгөтэй. Дотор: сайжруулсан нэхий эсвэл хиймэл үс болон түүнтэй дүйцэхүйц материал, Товч: хуванцар, бор ногоон өнгөтэй, Цахилгаан: хуванцар, бор ногоон өнгөтэй. Энгэрийн голд далд цахилгаан, ил 3 ширхэг товчтой, ил дарж оёсон бланктай. Халаас: энгэрийн дээд, доод хэсэгт тус бүр 2 ш тагтай, эзлэхүүнтэй ил халаастай. Нөхөөс: тохойн хэсэгт дарж оёсон зургаан өнцөгт нөхөөс байна. Нэмэлт: Бүсэлхийн дотор хэсэгт резин сойлттой.
		Өмд	Хар ногоон Орц: полиестр 65%, хөвөн 35%, Жин: 1м2-д 240гр, Халаас: урд гуяны дээд халаас ердийн, ар гуяных тагтай, ташааны халаас эзлэхүүнтэй, хоёр хуниастай тагтай байна. Нөхөөс: суудал болон өвдөг хэсэгт, Дотор: ширмэл, салдаг байх, нурууны хэсэг нь өмдний өнгөнөөс давсан байна.
		Дотуур цамц	Хар ногоон Орц: полиестр 50%, PAN /акрил/ 50%, Материал: Ноосон хираме сүлжмэл, Зах: дугуй хэлбэртэй, 2 давхарлаж нэхсэн байна. Хамгаалалт: мөр болон тохойны хэсэгт илгэн материалтай хамгаалалт байна.

				<p>Лого: энгэрийн зүүн хэсэгт УТХГ-ын логог нарийн ширмэлээр ширж оёно.</p> <p>Нэмэлт: Ханцуй, хормойн манжет 7см-ийн өргөнтэй зориулалтын сүлжээтэй байна. 1:1 гому сүлжээтэй.</p>
		Гутал	Хар	<p>Гадна: Арьс, шир, хром,</p> <p>Дотор: бүхэлдээ нэхий дотортой, эсгий улавчтай.</p> <p>Түрий: урт, өвдөгний хамгаалалттай, арын дээд хэсгээр ихэсгэх багасгах зориулалт бүрий үдээсээр тоноглогдсон, дээд зэргийн хатуу, нугалбараас хамгаалсан ширээр хийсэн байна.</p> <p>Ул: 3 давхар ултай, эсгий болон ширэн материалаар улыг давхарласан байна.</p> <p>Нэмэлт: -30 хэмийн хүйтэнд өмсөх боломжтой дулаахан, хөнгөн байх,</p>
2	Зуны хувцасны иж бүрдэл	Малгай	Цайвар ногоон, саарал, шаргал	<p>Орц: полиестр 65%, хөвөн 35%,</p> <p>Хэлбэр: дугуй хэлбэрийн бүтэн саравчтай,</p> <p>Лого: урд цохны хэсэгт УТХГ-ын логог нарийн ширмэлээр ширж оёно.</p>
		Гадуур хүрэм	Хар ногоон	<p>Орц: полиестр 65%, хөвөн 35%,</p> <p>Жин: 1м2-д 240гр,</p> <p>Зах: Босоо,</p> <p>Товч: хуванцар, хар ногоон өнгөтэй,</p> <p>Цахилгаан: хуванцар, бор ногоон өнгөтэй.</p> <p>Энгэрийн голд далд цахилгаан, ил 3 ширхэг товчтой, ил дарж оёсон бланктай байна.</p> <p>Халаас: энгэрийн дээд, доод хэсэгт тус бүр 2 ш тагтай, эзлэхүүнтэй ил халаастай, Зүүн энгэрийн дээд халаасанд үзэг, бал хийх зориулалт бүхий таслагчтай байна,</p> <p>Ханцуй: их бага ханцуйтай, тохой хэсэгт дарж оёсон нөхөөстэй, ханцуйн үзүүр манжеттай байна.</p> <p>Нэмэлт: Бүсэлхийн дотор хэсэгт резин сойлттой байна.</p>
		Өмд		<p>Орц: полиестр 65%, хөвөн 35%,</p> <p>Жин: 1м2-д 240гр,</p> <p>Халаас: урд гуяны дээд халаас ердийн, ар гуяных тагтай, ташааны халаас эзлэхүүнтэй, хоёр хуниастай тагтай байна.</p> <p>Нөхөөс: суудал болон өвдөг хэсэгт байна,</p> <p>Нэмэлт: Өмдний тахимын арын хэсэгт резин чангалагчтай байна.</p>
		Футболк	Хар ногоон	<p>Орц: полиестр 20%, хөвөн 80%,</p> <p>Зах: эргэсэн поло загвартай,</p> <p>Ханцуй: богино.</p> <p>Товч: хуванцар, хар ногоон өнгөтэй,</p> <p>Лого: энгэрийн зүүн хэсэгт УТХГ-ын логог нарийн ширмэлээр ширж оёно.</p>
		Дотуур цамц	Цайвар ногоон, саарал, шаргал	<p>Орц: полиестр 40%, хөвөн 60%,</p> <p>Зах: суурьтай эргэсэн захтай,</p> <p>Халаас: энгэрийн дээд хэсэгт тагтай, эзлэхүүнтэй, ил халаастай, Зүүн энгэрийн дээд халаасанд үзэг, бал хийх зориулалт бүхий таславчтай байна</p>

				Товч: цамцтай ижил өнгөтэй, хуванцар материалтай, Ханцуй: их бага ханцуйтай, эргүүлж шууж өмсөх зориулалттай товчлоостой, ханцуйн үзүүр манжеттай байна, Нэмэлт: Ар нь хөндлөн оруулга (кокетка)-тай байх
		Гутал	Шаргал	Гадна: илгэ, үхрийн арьс, сайн чанарын брезент, Дотор: энгийн ямааны арьсан дотортой, хөгц, бактери эсэргүүцэгчтэй хэлбэр алдахгүй, арьсан улавчтай. Түрий: хагас түрийтэй, Ул: хиймэл шир, хөнгөрүүлсэн резин, вебрам гэсэн 3 давхар ултай, Хамрын хатуулга: термопластик 1.7 мм, Зуузайн хатуулга: шир 1.5 мм,
3	Хавар, намрын хувцасны иж бүрдэл	Малгай	Хар ногоон	Орц: ноос 100%, Материал: Ноосон таки сүлжмэл Лого: Урд цохны хэсэгт УТХГ-ын логог нарийн ширмэлээр ширж оёно. Нэмэлт:
		Гадуур хүрэм	Хар ногоон	Орц: полиэстр 65%, хөвөн 35%, Жин: 1м2-д 240гр Зах: босоо, Дотор: Ширмэл дотор, Товч: хуванцар, бор ногоон өнгөтэй, Цахилгаан: хуванцар, бор ногоон өнгөтэй. Энгэрийн голд далд цахилгаан, ил 3 ширхэг товчтой, ил дарж оёсон бланктай байна. Халаас: энгэрийн дээд, доод хэсэгт тус бүр 2 ш тагтай, эзлэхүүнтэй ил халаастай, Зүүн энгэрийн дээд халаасанд үзэг, бал хийх зориулалт бүхий таславчтай байна. Нэмэлт: юүдэнтэй, их биетэй цахилгаанаар холбогддог. Бүсэлхийн дотор хэсэгт резин сойлттой байна.
		Өмд		Орц: полиэстр 65%, хөвөн 35%, Жин: 1м2-д 240гр, Халаас: урд гуяны дээд халаас ердийн, ар гуяных тагтай, ташааны халаас эзлэхүүнтэй, хоёр хуниастай тагтай, Нөхөөс: суудал болон өвдөг хэсэгт байна.
		Гутал	Хар	Гадна: 0,15-0.20 см зузаантай цэрэг армийн гутлын зориулалттай хромон арзгар хээтэй арьс, Дотор: Түрийний эх биед чийг татахгүй хөвөн зөөлөн даавуу, хамрын урд хэсэгт чийгтэхгүй бог малын шевро, арьсан улавчтай. Түрий: хагас түрийтэй, түрийний урт 20-25 см. Ул: зориулалтын ул, хагардаггүй, хөлддөггүй, халтирдаггүй элэгдэлд тэсвэртэй, Нэмэлт: хамрын хатуулгатай, зориулалтын ширэн зуузайтай, тасардаггүй, саардаггүй,

				үзүүрийн бэхэлгээ сайтай, эрчлээстэй үдээс байна. Хэлний арьс нь хонь болон ямааны арьс буюу шевро байна.
4	Албаны хувцасны иж бүрдэл	Дүрэмт хувцас хослол	Хар ногоон	Орц: полиэстр 40%, ноосон даавуу, ноос, хөвөн 60%, Эрэгтэй: пиджак, өмд Эмэгтэй: пиджак, банзал/өмд Товч: хуванцар, хар ногоон өнгөтэй,
		Дотуур цамц	Цагаан, цайвар ногоон	Сорочкон цамц
		Зангиа	Хар ногоон	Даавуун материал бүхий Лого: Зангианы өргөссөн хэсэгт УТХГ-ын логог нарийн ширмэлээр ширж оёно.
		Гутал	Хар	Түрийгүй Арьсан материалтай
5	Тэлээ	Хар ногоон	Ременэн материал, усад хэрэгсэл зүүж тогтоох боломжтой 2-оос доошгүй гогцоотой. Төмөр аралтай,	
6	Тусгай хамгаалалттай газрын лого, тэмдэг	<ul style="list-style-type: none"> • Өвөл, хавар намар, зуны гадуур хүрмийн арын дээд хэсэгт “УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР” гэсэн шар өнгийн утсаар 3,5 см-ийн өндөртэй бичиглэлийг 2 эгнээ ширж оёно. • Өвлийн хүрэм, хавар намрын хүрэм, зуны гадуур хүрэм, дүрэмт хувцасны пиджакийн зүүн талын ханцуйны дээд хэсэгт УТХГ-ын бэлгэдэл лого тэмдэг хадна. Зүүн энгэрийн халаасны дээд ирмэгт “БОАЖЯ” нэрийн тэмдгийг тулгаж, дээр нь Монгол Улсын төрийн далбааг оёно. Баруун энгэрийн халаасны дээд хэсэгт хүний нэр хадах зангуутай ремен оёно. 		

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2022 оны 10 дүгээр сарын 16 өдрийн
4156 дугаар тушаалын 3 дугаар хавсралт



1. Өвлийн хувцасны иж бүрдэл



2. Хавар, намрын хувцасны иж бүрдэл



3. Зуны хувцасны иж бүрдэл



4. Дүрэмт хувцасны иж бүрдэл

